



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/06

Бат-Өлзий сум

Эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, 26 дугаар зүйлийн 26.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж ажиллах зөвлөмж”-ийн 2.2, 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Эцэг, эхийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн бүрэлдэхүүн: О.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
Э.Буянтогтох (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн)
Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)
Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн)
Ц.Баасанжав (Насан туршийн боловсролын арга зүйч)
Г.Хулан (Нийгмийн ажилтан)
М.Бат-Өлзий (Жолооч)

2.Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл” хуралдаж дарга, нарийн бичгийг сонгон, ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг жилийн бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлж ажиллахыг Зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/09 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Н.БАТ-ЭРДЭНЭ